

MICC ТЭМДЭГЛЭЛ

MICC.mn

2013 ОНЫ 11 ДУГААР САРЫН 13 (3)

14 хоног тутам гарна

MONGOLIA INTERNATIONAL CAPITAL CORPORATION — Монголын тэргүүлэх хөрөнгө оруулалтын банк

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭ

- Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Шивээ-Овоо ХК, Багануур ХК-ийн төрийн мэдлийн хувьцааг Эрдэнэс МГЛ компанид шилжүүлжээ.
- ОХУ-ын ИСТ групп болон төрийн өмчит Ростех компани хамтран Якут улсад орших газрын ховор элементийн Томтор ордод олборлолт явуулах юм.
- Уул уурхайн яам, Монголын Төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбоо Монгол улсад төмөрлөгийн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд хамтран ажиллах санамж бичгийг байгууллаа.
- Оюу Толгой буюу Turquoise Hill Resources компанийн хувьцаа (NYSE:TRQ) Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр өнөөдрийн байдлаар 4.82 доллараар арилжаалагдаж байна. Энэ нь өчигдрийнхтэй харицуулахад 1.23 хувиар унасан, оны эхэн үетэй харьцуулахад 40 хувиар унасан үзүүлэлттэй байна.
- Хятадын аж үйлдвэрлэлийн эрчмийн үзүүлэлтийг илтгэдэг "Purchasing Manager Index"-ын үзүүлэлт өнгөрсөн 10-р сард 51.4 гарчээ. Энэ нь сүүлийн хагас жилийн хамгийн өндөр үзүүлэлт юм.
- Нефтийн ханш дөрвөн сарынхаа доод түвшинд хүрчээ.
- Еврогийн ханш суларлаа.
- Оросын нүүрсний экспорт нэмэгджээ. 12.6 хувиар өсч 117,83 сая тоннд хүрчээ.
- Монгол улс 10-р сард 2 сая тонн чулуун нүүрс экспортолж, 95,8 сая долларын орлого олсон нь сүүлийн 10 сарын хамгийн өндөр үзүүлэлт юм.
- Хятад төмөр замын хөрөнгө оруулалтаа нэмэгдүүжээ.

Монголын хөрөнгийн зах зээл



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ зээлийн 90 орчим хувийг Мээлдэг, Монголын хамгийн өндөр үнэлгээтэй 20 хувьцаат компанийн хувьцааны үнийг нэгтгэж үзүүлдэг "ТОП 20 Индекс" өнөөдрийн байдлаар 14,419-д хүрч өчигдрийнхөөс 199 нэгжээр буюу 1.36 хувиар буурсан байна. Ер нь сүүлийн жил гаруй хугацаанд Топ 20 Индекс 13000-аас 14000-ын хооронд нилээд хэлбэлзлээ. Өөрөөр хэлбэл Монголын хөрөнгийн зах зээл дээрх компаниудын хувьцааны үнэ сүүлийн жил гаруй хугацаанд (дунджаар) өссөн ч үгүй, унасан ч үгүй. Үүнийг доорх зургаас тодорхой харж болно.

Топ 20 Индекс 2008 оноос хойш





PROPHECY COAL КОМПАНИ 30-50 МЯНГАН ТОНН НҮҮРС ОЛБОРЛОНО

Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Канадын Prophecy Coal компани Улаан-Овоогийн орд дахь үйл ажиллагаагаа дахин эхлүүлснээ даваа гаригт мэдэгджээ. Энэ компанийхан тээвэрлэлт, аюулгүй байдал хариуцсан бүх ажилчнаа эргүүлэн ажилд авсан төдийгүй гурван экскаватор, зургаан самосвал, 20 гаруй ачааны машинаа тэнд аваачсан байна. Цаг агаар таатай байвал тэд 11,12 дугаар сард 30-50 мянган тонн нүүрс сар бүр олборлоно гэж төлөвлөсөн гэх хайгаа мэдээлжээ. Prophecy Coal компанийхан Улаан-Овоо дахь олборлолтоо түр хугацаагаар зогсоогоод байсан ч нүүлийн 2 сард худалдан авагчидтай гэрээ байгуулж чадсан бөгөөд эрэлт хангалттай байвал хойд хөршийн ажлын нэгжүүдэд сард 30 мянган тонн нүүрс борлуулахаар тохирсон гэнэ. Тэд 2010 оноос хойш дээрх уурхайд авто зам гүүр, кэмп барих, уул уурхайн машин төхөөрөмж худалдан авах болон бусад дэд бүтэц зэрэгт 55 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулжээ. Одоогоор Зэлтэрийн боомтыг ашиглах талаар Монголын Засгийн газартай хэлэцэж буй аж. ОХУ-ын хилээс 17, Монгол, ОХУ-ыг холбосон төмөр замаас 120 км-ийн зайд оршдог Улаан-Овоогийн орд нь 174 сая тонн баалгаат, 34 сая тонн боломжит нөөцтэй гэж тогтоожээ. Ордын нүүрсний чанар нь эхний найман жилд угаах шаардлагагүй бөгөөд экспертлөхөд тохиромжтой гэнэ.

ТВИТТЕР КОМПАНИ IPO АМЖИЛТТАЙ ГАРГАЛАА

Твиттер компани нь IPO буюу хувьцаагаа олон нийтэд зарласанаар компанийхаа нийт үнэлгээг 1.82 тэрбум доллараар өсгөж чаджээ.

Өнгөрөгч оны 5 сард цахим ертөнцөд хамгийн том IPO-г Фэйсбүүк компани хийж нийт 14.2 тэрбум доллараар үнэлэгдсэн билээ. Жил хагасын өмнө 28 ам.доллараар олон нийтэд гарч байсан Фэйсбүүк компанийн хувьцааны үнэ өнөөдөр 47 ам.долларт хүрсэн байна.

Твиттер нийт 70 сая ширхэг хувьцаа гаргаж нэгж бүрийн үнийг 26 ам.доллараар тогтоожээ.

Цахим ертөнцөд нэгдээд 6 жилийн нүүр үзэж байгаа Твиттер компани зар сурталчилгааны бизнесээрээ 230 сая гаруй хэрэглэгчдийг өөртөө нэгтгэж чадсан байна. Жилээс жилд Твиттер компанийн орлого 2 дахин өсөж байгаа нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг маш ихээр татаж байгаа тухай гүйцэтгэх захирал Дик Костоло хэлжээ.

Хувьцааны үнийг 26 ам.доллараар тогтоосон нь компани болон худалдан авагчдад 2-ууланд нь боломжийн үнэ болсон гэж Gamco Investors Inc сангийн удирдагч Лоуренс Хэверти хэлсэн байна.

Компанийн хувьцаа 2013 оны 11 сарын 8-ны өдөр Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж эхэлсэн ба даруй 78% ба 18 ам доллараар өсөж 44 америк долларт хүрчээ. Яг өнөөдрийн байдлаар 42.01 ам доллараар арилжаалагдаж байна.

THIS IS THE MICC JOURNAL, A BI-MONTHLY FINANCE AND ECONOMICS PAPER PUBLISHED BY MICC, THE LEADING INVESTMENT BANK IN MONGOLIA.

МIСС хөрөнгө оруулалтын банкны тухай
МIСС нь компанийн санхүүжилт, үнэт цаасны арилжаа, судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг цогц үйлчилгээг дотоод гадаадын харилцагчиддаа санал болгодог Монголын ууган хөрөнгө оруулалтын банк юм.

МIСС ТЭМДЭГЛЭЛ – ийн тухай
Хоёр долоо хоног болгон гарах энэ бяцхан сонин танд эдийн засаг, санхүүгийн мэдээлэл өгөх боловч хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөхгүй.

Таны эрсдэл таны хариуцлага.

Эрхлэгч: Э. Оюу.

2013/10/16

Мэдээллийн эх сурвалж:
Bloomberg, Монголын
Хөрөнгийн Бирж, MSCI Barra,
OECD.